

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖИЙН  
12 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТ**

2020 оны 12 дугаар сарын 30

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1	2019.10.11	2019.10.09	A/1054	<ul style="list-style-type: none"> <li>- "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-т 2020 оны 12 дугаар сарын 01-нээс 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд хариутай 11, хариугүй 10 бичиг нийт 21 албан бичиг ирсэн ба шийдвэрлэлт 100 хувьтай байна.</li> <li>- "Багануур үйлдвэрлэл, төхнолийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-үүдад хариугүй 36 албан бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна.</li> </ul>
2	2020.01.28	2020.01.27	A/108	<ul style="list-style-type: none"> <li>- 1.6 дугаар заалтын дагуу Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, хаалганы бариулыг 2 цаг тутамд спиртээр тогтмол ариутгаж байна.</li> <li>- Захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гаригт <a href="mailto:zendmaal@gmail.com">zendmaal@gmail.com</a> цахим хаягт илгээн тайлагнасан.</li> <li>- Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, цаг үеийн мэдээг <a href="http://www.baganuur-itp.mn">www.baganuur-itp.mn</a> цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтэд түгээн ажиллаж байна.</li> </ul>
3	2020.02.07	2020.02.07	A/168	<ul style="list-style-type: none"> <li>- 3 дугаар заалтын дагуу 12 дугаар сарын 18-ны өдөр Шинэ жилийн баярыг утсан бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, тайланг дүүргийн ЗАА-нд 2020.12.21-ний өдрийн 237 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</li> <li>- Захирамжийн биелэлтийг 14 хоног тутам НЗДТГ-ын ХШҮХ-т тайлагнан ажилласан.</li> </ul>
4	2020.12.11	2020.12.11	A/1280	<ul style="list-style-type: none"> <li>- Газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн A/38 дугаар тушаалаар тогтоосон хугацаанд байгууллагын үйл ажиллагааны цагийг хэвийн горимоор буюу 08:30-17:30 цагаар тогтоосон.</li> <li>- Цахимаар ажиллаж байгаа 4 ажилчид ERP системээр цагийг бүртгүүлж байна.</li> <li>- Бусад ажилчид ажил эхэлсэн өдрөөс цагийг цаг бүртгэлийн төхөөрөмжнөөс бүртгүүлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> <li>- Дээрх тушаалын 2 дугаар хавсралтаар ХАБЭА, Халдвар хамгааллын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> <li>- 12 дугаар сарын 13-ны өдөр даргын зөвлөлийн хурлыг цахимаар зохион байгуулж, 14-ний өдөр ариутгал, халдваргүйтгэлийг "Их хурай" ХХК-аар хийлгэсэн.</li> </ul>

				<ul style="list-style-type: none"> <li>- Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө биеийн халууныг хэмжих амны хаалт зүүлгэн, гарыг халдвартгуйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</li> <li>- Ажлын байрны цэвэрлэгээг тогтмол хийх, хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгах, ажлын байрыг өдөр бүр агааржуулах, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</li> <li>- Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг буртгэх QR кодыг зааврын дагуу хэвлэн иргэдийн орох хэсэгт ил харгадахаар байршуулсан.</li> <li>- Уг заалтын хэрэгжилтийг хангах, ажилтнуудын ажил үүргийг бүрэн гүйцэтгүүлэх, цаг ашиглалтын зөв төлөвлөлтэд Захиргааны болон Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтнүүд хяналт тавин ажиллаж байна.</li> <li>- УОК-ын үүрэг чиглэлийн дагуу 2020.12.23-ны өдрөөс Нийслэлд бүх нийтийн бэлэн байдлын зэрэглэлийг хэсэгчилсэн байдлаар тогтоож байгаатай холбогдуулан ДЗХ-аар хэлэлцэж, Газрын дарга, бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн болон Үйлдвэрлэл технологийн албаны Ахлах мэргэжилтэн нийт 3 ажилтант ажлын байранд, 9 ажилтанг цахимаар ажиллуулахаар байгууллагын дотоод зохион байгуулалтыг хийсэн.</li> </ul>
--	--	--	--	---



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Э. Энхзаяа* Э. ЭНХЗАЯА